

**АПУ ДЭЙРИ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН  
2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН  
МЭРГЭЖИЛТЭН

Ж.БАТЗОЛБОО

ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАСАН:

АПУ ДЭЙРИ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Г.БАЯРМАГНАЙ

ХАБЭА-н ИНЖЕНЕР

Т.ӨЛЗИЙЖАРГАЛ

## АГУУЛГА

НЭГ. АПУ ДЭЙРИ ХХК-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1 Төслийн товч танилцуулга.....	3
1.2 Үйлдвэрийн бүтэц, зохион байгуулалт.....	4
1.3 Үйлдвэрийн хүчин чадал.....	5-6
1.4 Техник, тоног төхөөрөмж.....	7
ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ТАНИЛЦУУЛГА.....	8
ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН АЖЛУУД.....	9-11
3.1 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	9-11
3.2 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	12
3.3 Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө.....	13
3.4 Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	14
3.5 Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	15-20
3.6 Байгаль орчны менежментийн зардлын гүйцэтгэл.....	21
ДӨРӨВ. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	22
4.1 Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....	22-23
4.2 Түүх, соёлын өвийг хамгаалах хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	24
4.3 Төлөвлөгөөний хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	25-26
4.4 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	27-31
4.5 Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	32-35
4.6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	36-37
ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ГҮЙЦЭТГЭХЭД ЗАРЦУУЛСАН ЗАДАРГАА.....	38-40
ЗУРГАА. ДҮГНЭЛТ.....	41
ЗУРГАА. ХАВСРАЛТУУД.....	42--66

## НЭГ. АПУ ДЭЙРИ ХХК-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Төслийн товч танилцуулга


Төслийн нэр:	“Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр-ЭКО ДЭЙРИ” төсөл
Төсөл хэрэгжүүлэгч:	“АПУ ДЭЙРИ” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011695053
Регистрийн дугаар:	6229654
Холбоо барих дугаар:	88036838, 99242686
Компанийн үйл ажиллагааны чиглэл:	<ul style="list-style-type: none"><li>- Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл</li><li>- Жүүс, ундаа үйлдвэрлэл</li><li>- Сүү, сүүн бүтээгдэхүүн, жүүсний бөөний болон жижиглэнгийн худалдаа</li><li>- Гадаад худалдаа</li></ul>
Төслийн байршил:	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 19-р хороо (шинээр) Номин агуулах худалдааны төвийн урд, Улаанбаатар сувиллын чанх хойно, өөрийн эзэмшлийн газар
Төслийн ач холбогдол:	Хэрэглэгчдэд эрүүл зөв хоололтод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн хүчин чадал, бүтээгдэхүүний нэр төрлийг байнга нэмэгдүүлж ирснээр дотоодын зах зээлд тэргүүлэгчдийн нэг болтлоо өсөн дэвжиж, импортын бүтээгдэхүүнийг орлох, дотоодын зах зээлийг бүтээгдэхүүнээр хангах чиглэлээр гарсан Монгол Улсын бодлого, холбогдох хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэж, тодорхой хэмжээний хувь нэмэр оруулж байгаа чухал ач холбогдолтой.
Үйлдвэрлэлийн хүчин чадал, тоног төхөөрөмж:	Жилд 45 сая литр сүү үйлдвэрлэх, 150 тн бүтээгдэхүүн боловсруулах Герман улсын GEA брэндийн тоног төхөөрөмж бүхий боловсруулах хэсэг, Швед улсын Tetrapak, Ecolean савлах шугам, Япон улсын Elorak, EHEDG бүрэн автомат тоног төхөөрөмж
Ажиллах хоног:	365 хоног
Ажиллах хүчин:	49 төрлийн ажлын байранд 452 ажилтантай
Уур, дулаан хангамж:	“ДЦС-3” ТӨХК
Цахилгаан хангамж:	“ДЦС-3” ТӨХК
Цэвэр усан хангамж:	Төвийн шугамд холбогдсон. УСУГ-тай гэрээгээр хамтран ажилладаг.
Хаягдал ус:	
Хөргөлтийн төхөөрөмж:	R-404A, R-134a
Аюултай хог хаягдал	Химийн аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх түр зөвшөөрөл бүхий “Түмэн Эгшиг” ХХК-тай гэрээтэй.
Хог хаягдал:	Дахивар хог хаягдлыг хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүдэд борлуулах, хадгалах, энгийн хаягдлыг нийслэлийн заасан хогийн цэгт хаях, тээвэрлэх үүрэг хүлээсэн “Эко орчин” ХХК-тай гэрээтэй.



Зураг 1. Үйлдвэрийн байршил

## 1.2 Үйлдвэрийн бүтэц, зохион байгуулалт

АПУ ДЭЙРИ ХХК нь 3 блок барилга бүхий оффис, үйлдвэр, лаборатори, түүхий эд, туслах материалын агуулах, аммиак хөргөлтийн цех гэсэн үндсэн хэсгүүдтэй бөгөөд гадна хөргүүртэй контейнер 9ш, харуулын байр, нэрийн барааны дэлгүүртэй.



Зураг 2. Үйлдвэрийн зохион байгуулалтын бүдүүвч зураг

### 1.3 Үйлдвэрийн хүчин чадал


Үйлдвэрийн нийт талбайн хэмжээ: 5347.9м<sup>2</sup>

Үйлдвэрлэлийн хүчин чадал:

- Хоногт 50-70 тонн үнээний түүхий сүү хүлээн авах;
- Тетрапак савлах машин цагт 7000-8000 литр бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
- Элопак-6 савлах машин цагт 5000-6000 литр бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай.

**Үйлдвэрийн тоног төхөөрөмж:** Герман улсын GEA брэндийн тоног төхөөрөмж тоноглогдсон, Швед улсын Tetra Pak, Ecolan савлах шугам, Япон улсын Elopak буюу Европын холбооны сүү боловсруулах үйлдвэрийн стандартын дагуу баригдсан бүрэн автомат үйлдвэр юм.

**Товч танилцуулга:** Сүүний үйлдвэр нь 2014 онд ашиглалтад орж бие даасан үйлдвэр болсон. Үйлдвэрийг шинэчлэх ажлыг 2012 оноос шинэ сүүний үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэн дэлхийд тэргүүлэгч Герман улсын GEA брэндийн тоног төхөөрөмж бүхий боловсруулах хэсэг болон Швед улсын Tetra Pak, Ecolan савлах шугам, Япон улсын Elopak буюу Европын холбооны сүү боловсруулах үйлдвэрийн стандартын дагуу баригдсан, бүрэн автомат тоног төхөөрөмж бүхий хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт үйлдвэрийг ашиглалтанд оруулсан. Нийтдээ 57 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж хэрэглэгч олондоо хүргэн ажиллаж байна.



Зураг 3. Үйлдвэрийн барилга байгууламжийн план зураг



*Зураг 4. Үйлдвэрийн байр*




*Зураг 5. Оффисын байр*



*Зураг 6. Ажилчдын цайны газар*



*Зураг 7. Агуулахын байр*



*Зураг 8. Ариун цэврийн өрөө*

## 1.4 Техник, тоног төхөөрөмж

АПУ ДЭЙРИ ХХК-ийн сүүний үйлдвэрийн гол дамжлагууд нь Герман улсын GEA брэндийн тоног төхөөрөмж бүхий боловсруулах хэсэг болон Швед улсын Tetra Pak, Ecolean савлах шугам, Япон улсын Eiorak буюу Европын холбооны сүү боловсруулах үйлдвэрийн стандартын дагуу баригдсан, бүрэн автомат тоног төхөөрөмж бүхий хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт үйлдвэр ба чанарын баталгаажуулалтын тусгай программ болох “QUALASS” чанарын хяналтын системийн дагуу гүйцэтгэдэг. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа олон улсын ISO 22000:2018, ISO 9001:2015 цуврал стандартуудыг нэвтрүүлснээр үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, түүхий эд материал, бэлэн бүтээгдэхүүний иж бүрэн хяналтын тогтолцоог шинээр мөрдөж, дотоодын хяналтыг тогтмол тавьж ажиллаж байна.



*Зураг 9. Боловсруулах хэсгийн тоног төхөөрөмж*



*Зураг 10. Цагаан идээний хэсгийн тоног төхөөрөмж*



*Зураг 11. Тетрапак савлах машин*



*Зураг 12. Итгэмжлэгдсэн лаборатори*

## **ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ТАНИЛЦУУЛГА**

АПУ ДЭЙРИ ХХК-ийн бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд нь “Тогтвортой хөгжил”-ийн үндсэн суурь зарчим болох “НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, БАЙГАЛЬ ОРЧИН”-ы тэнцвэртэй хөгжлийг ханган нийгэм, эдийн засаг, хүн баялагт үнэ цэн бүтээхэд чиглэн ажилладаг билээ. Байгаль орчин тогтвортой хөгжлийн стратеги нь АПУ ДЭЙРИ ХХК-ийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг ба бүхий л үйлдвэр, үйл ажиллагааг байгаль орчны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, аюултай материал, ус, эрчим хүч болон бусад байгалийн нөөцийн хэрэглээг хэмнэх, үүсэх хог хаягдлын хэмжээг багасгах, хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах боломжийг нэмэгдүүлэх зэрэг зарчмуудыг баримтлан ажилласаар байна. Иймд 2025 оны тогтвортой хөгжлийн стратегийн хүрээнд “Илүү сайхан дэлхийг цогцлооё” уриан дор үйлдвэрлэл, үйл ажиллагааны хүрээнд байгаль орчны менежментийг хэрэгжүүлэн ажиллалаа. 2025 онд байгаль орчны менежментийн тогтолцоог сайжруулах, хэрэгжүүлэлтийг нэмэгдүүлэх, хог хаягдлын менежментийг сайжруулах, ажлын байрны таатай орчин бүрдүүлэх зэрэг үндсэн зорилтын хүрээнд ажилласан билээ. Хог хаягдлын менежментийн хүрээнд хог хаягдлын 3R стратегийг үйлдвэр, нэгж хэсгүүдэд хэрэгжүүлэн хог хаягдлын цэгүүдийг 5S зарчмын дагуу сайжруулан хог хаягдлын ангилан ялгалтыг нэмэгдүүлж байна. Түүнчлэн үйлдвэрлэлээс гарч буй бүх төрлийн хатуу хог хаягдлын хэмжээг бууруулах, ландфиллд хаягдах хаягдлыг багасгах, дахивар хог хаягдлаа эргүүлэн ашиглах, дахин боловсруулахад чиглэн ажиллаж нийт хог хаягдлын хэмжээгээ энэ үеийн өмнөх онтой харьцуулахд 30% -иар бууруулж дахин боловсруулах компаниудын түншлэлээ нэмэгдүүллээ. Тухайлбал аюултай болон химийн хорт бодисын сав баглаа боодлыг дахин боловсруулах үйлдвэр Түмэн Эгшиг ХХК, Гялгар хаягдлыг Мультипак ХХК болон Энгийн хатуу хог хаягдлыг Эко орчин ХХК-д тус тус нийлүүлж байна.

**ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН АЖЛУУД**

**3.1 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Нийт зардал, сая төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<b>Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө</b>					
1	Орчны тоосжилт үүсэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоосжилт үүсч болзошгүй	Үйлдвэрийн гадна орчныг тохижуулах, зүлэгжүүлэх, тогтмол цэвэрлэж байх. Дулааны улирлуудад саарал усаар услах, дахин ашиглах цэвэршүүлсэн усаар авто зогсоол болон бусад шороон зам талбайг услах	4-9 саруудад	-	Газрын тухай хууль, Хөрсний бохирдлын тухай хууль, MNS 5850:2019 (хөрсний чанар, хөрс бохирдуулах бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ)
2	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр агаарт түгээмэл тархалттай бохирдуулагч бодис (CO, NOx, SO2) ялгарах	Түүхий эд болон эцсийн бүтээгдэхүүний тээвэрлэлтэд ашиглах машиныг жил бүр тогтмол техникийн үзлэг оношилгоонд оруулах, агаар бохирдуулсны төлбөр төлөх	Жилд нэг удаа	3.4	“Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль”, MNS 4585:2016 (Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага)
<b>Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө</b>					
3	Үйлдвэрийн хаягдал ус нь стандартын шаардлага хангасан байх	Үйлдвэрийн хаягдал усны чанарын шинжилгээ хяналтыг тогтмол хийлгэх. Өөрийн лабораторид сар бүр хийхээс гадна холбогдох итгэмжлэл бүхий лабораториор шинжилгээ хийлгэн, дүгнэлт гаргуулах	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан		“Усны тухай” хууль (хүрээлэн байгаа орчин усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд тавигдах ерөнхий шаардлага)-MNS 6561:2015 (хүрээлэн буй орчин, усны чанар хаягдал ус) MNS 4943: 2015, ( Хүрээлэн буй орчин, ус ашиглалт, хамгаалалт техникийн шаардлага) MNS 6694:2017
4	Төслийн хүрээнд усны нөөц ашиглах, хомсдох	Үйлдвэрийн цех бүрийн усны хэрэглээг нарийвчлан тооцох, нэгж бүтээгдэхүүнд зарцуулагдах усны нормыг боломжит бага хэмжээнд байлгах. Усны нөөцийг хэмнэх, дахин ашигласан усны хэмжээ, хэрэглээг нэмэгдүүлэх	Жилийн туршид	Сайжруулалтын багуудын нэмэлт урамшуулал	
5	Ус бохирдуулсны төлбөр төлөх	Үйлдвэр	Жилдээ 1 удаа	5.4	
<b>Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө</b>					
6	Үйлдвэрлэлийн болон ахуйн хатуу хог хаягдал ил задгай үүсэх, хаягдлыг зайлуулалгүй удааснаар хөрс бохирдох	Тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай хатуу хог хаягдал шилжүүлэх, устган зайлуулах гэрээ байгуулах, сунган ажиллах - хатуу хог хаягдлыг ангилан ялгах боломжтой шаардлага хангасан хогийн төв цэгийг сайжруулах - хог хаягдлыг тогтмол хугацаанд шилжүүлэх	Жилийн турш	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан	Хог хаягдлын тухай хууль, MNS 5344:2003 - Хог хаягдлыг ангилан ялгаж хаях тухай журам Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль

7	Хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэх, зөөгдөх	Үйлдвэрийн нийт ногоон байгууламж бүхий талбайг тордон арчлах, услах, машин техникийг тогтоосон зам талбайгаар явуулах	Жилийн турш	Тодорхойлох боломжгүй	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
8	Орчны сөрөг нөлөөллийг бууруулах	Нийт эзэмшил талбайн 10%-иас доошгүй талбайг зүлэгжүүлэх	II, III улиралд	2.0	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
<b>Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээний төлөвлөгөө</b>					
9	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	“Тэрбум мод” НУРИ ХХК-н Инчон мөрөөдлийн цэцэрлэгт хүрээлэнд 100 ш нарс, 100 ш шинэс мод тарьж ургуулах.	5-9 сар	3.0	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
10		“Тунгалаг Туул” төсөл болон бусад олон нийтийн үйл ажиллагаа, аян арга хэмжээнд хамтран ажиллах	6-9 сар	1.0	
<b>Тодорхойлсон нийт төсөв:</b>				<b>14.8</b>	

*Хүснэгт 1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах ажлын төлөвлөгөө*

№	Хог хаягдлын ангилал	Ангилалд хамаарах	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Шилжүүлэх давтамж	Нийт зардал, сая төг	Баримтлах стандарт аргачлал
1.	Ахуйн буюу энгийн хог хаягдал	Доорх 3 ангилалд үл хамаарах бусад үйлдвэрээс гарах энгийн хог хаягдал	Үйлдвэрлэл үйл ажиллагаанаас гарч байгаа хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, боловсруулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	Жилийн турш	Тухай бүрт	Гэрээнд заагдсан үнийн дүн	“Хог хаягдлын тухай хууль”, “Эрүүл ахуйн тухай хууль”-ийн 4.4.3,
2.	Аюултай хог хаягдал	Химийн хорт болон аюултай бодисын сав баглаа боодол, химийн бодисын үлдэгдэл, хаягдал зай	Аюултай хаягдлыг “Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах” тусгай эрх бүхий компанитай хамтран ажиллана	Жилийн турш	Сардаа 1 удаа	6.0	
3.	Хог хаягдлын сав	3R менежментийн дагуу ажлын байран дээр хог хаягдлыг ангилан ялгах	Компанийн хэмжээнд 3R менежментийн дагуу хогийн сав шинээр авч байршуулан ангилан ялгах, ажилтнуудад сургалт орох	Жилийн турш	-	2.0	
4.	Нийтийн их цэвэрлэгээ	Үйлдвэрийн эзэмшил талбайд ил задгай хаягдсан хогийг ангилан ялгаж, цэвэрлэх	Компанийн эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50 метр хүртэлх газрын хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах, ногоон байгууламжийн арчилгааг хийх;	Улиралд 1 удаа	-	Үйл ажиллагааны зардлаар	“Эрүүл ахуйн тухай хууль”-ийн 4.4.3
5.	Шингэн хаягдал	Спирт болон пивоны шаар	Спиртийн шаар, пивоны шаар, хаягдлыг дахин боловсруулах, малын тэжээл бэлтгэн нийлүүлэх ажлын хүрээнд шингэн байдлаар малчид, фермерүүдэд тогтмол нийлүүлж байна.	Жилийн турш	Тодорхойлох боломжгүй	Гэрээнд заасан үнийн дүнгийн дагуу + үйл ажиллагааны зардал	
6.	Дахивар хог хаягдал	Хаягдал гялгар уут	Хаягдал гялгар уут дахин боловсруулах компанитай хамтран ажиллана.	Жилийн турш	Тодорхойлох боломжгүй	Гэрээнд заасан үнийн дүнгийн дагуу + үйл ажиллагааны зардал	
<b>Тодорхойлсон нийт төсөв:</b>						<b>8.0</b>	

*Хүснэгт 2. Гарах хог хаягдлын ангилал*

### 3.2 Хог хаягдалын менежментийн төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулах үүднээс ахуйн болон үйлдвэрийн гаралтай хатуу, шингэн, хог хаягдлыг байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө багатайгаар хэрхэн цуглуулж, ангилан, дахин ашиглах, зайлуулах арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлсэн.

№	Хог хаягдлын төрөл		Жилд гарах хэмжээ	Зайлуулах арга хэмжээ
1.	Устгах дахин ашиглах боломжгүй хог хаягдал	Ангилан ялгах боломжгүй ахуйн хог хаягдал	65 тн	“Эко Орчин” ХХК
2.	Дахин ашиглах боломжтой энгийн хог хаягдал	Шуудай	500 кг	“Эко Орчин” ХХК
3.		Хуванцар	600 кг	“Эко Орчин” ХХК
4.		Модон поддон	12 тн	“Эко Орчин” ХХК
5.		Гялгар уут	850 кг	“Мультипак” ХХК
6.		Шүлтийн шуудай	1.48 тн	“Түмэн эгшиг” ХХК
7.	Аюултай шингэний хаягдал	850 л		
8.	Химийн бодисын үлдэгдэл агуулсан эсвэл бохирдсон сав баглаа боодол, шингээгч, бохир алчуур, фильтрийн материал, ажилласан тос	1 тн		

Хүснэгт 3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

### 3.3 Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

№	Зохион байгуулах ажил	Авсан арга хэмжээ	Хийгдсэн хугацаа	Гарсан зардал, сая	Үнэлгээ	Хувь
1.	Хог хаягдлыг бууруулах багын ажиллагаа	Байгаль орчинд гаргаж байгаа химийн бодис, физик нөлөөлөл, хог хаягдалын хэмжээг бүртгэж тэдгээрийг багасгах, цэвэрлэх, төвлөрсөн цэгт цуглуулж ажилласан	2025	5.45	A	100%
2.	Стандарт хогийн цэг барих, ангилан ялгах	Хогийн цэгт хаалт хашлага хийж сайжруулах	2025	5.9	A	100%
3.	Хог хаягдалын гэрээг сунгуулах	“Эко Орчин” ХХК “Түмэн эгшиг” ХХК	2025.04.01	Гэрээнд заагдсан дүнгээр	A	100%
4.	Эзэмшил газрын ойр орчмын ногоон байгууламжийг нөхөн сэргээх, мод тарих, ургамалжуулах	2025 онд Тэрбум мод үндэсний хөдөлгөөн “Инчон” мөрөөдлийн цэцэрлэгт хүрээлэнд 200ш нарс, шинэс мод тарив	2025.11.07	3.0	A	100%
5.	Аюул, эрсдэл өндөртэй ажлын байран дээрх ажилтнуудыг гэнэтийн ослын даатгалд хамруулах	Гэнэтийн ослын даатгалд 137 ажилтан хамруулав	2024.12.05-2025.12.06	12.33	A	100%
6.	Компанийн ойр орчмын гадна талбайд бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах	Улирал тутам компанийн ойр орчмын гадна талбайд бүх нийтийн цэвэрлэгээ, эмх цэгц тогтоох ажлуудыг хийж хэрэгжүүлсэн	2025 он	1.0	A	100%
<b>Тодорхойлсон нийт төсөв:</b>				<b>27.68</b>		

*Хүснэгт 4. Компанийн удирдлагын зүгээс хийж гүйцэтгэсэн ажлын үнэлгээ*

### 3.4 Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хийгдэх ажил	Зарцуулсан зардал мян,төг	Хариуцах эзэн	Үнэлгээ	Хувь
Химийн бодисыг тээвэрлэхдээ сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдал, машин техник, тээврийн хэрэгслийн эвдрэл гэмтлийг хянадаг байх	-	Гэрээнд аюулгүй ажиллагааны заавар тусгагдсан байдаг. Журмыг тээвэрлэгч нарт танилцуулдаг. Худалдан авалтын ажилтан хариуцна.	A	100%
Жолооч, ачигчид тээвэрлэлтийн явцад эрсдэл тохиолдсон үед авах арга хэмжээ, зааварчилгааны талаар мэдлэгтэй байх, асгарч алдагдсан үед хураан авах, саармагжуулах, хоргүйжүүлэх багаж хэрэгсэл, гал унтраах багаж хэрэгслийг бэлтгэн, бэлэн байлгах	-		A	100%
Химийн бодисуудыг битүүмжлэл сайтай хуурай сэрүүн, агааржуулалт сайтай агуулахад халаалт, гал авалцах эх үүсвэрээс хор аюулын мэдээлэлд заасны дагуу хадгалах	-	Ложистикин менежер	A	100%
Химийн бодисыг хадгалах журам, аюулгүй ажиллагааны талаар ажиллагсдад мэдээлэл олгох, сургалт зохион байгуулах	-	ХАБЭА-н инженер, Химич	A	100%
Агуулахын гадна болон дотор химийн бодисын хор аюулыг анхааруулсан тэмдэг тэмдэглэгээг байршуулах, агуулахын орчим ил гал гаргах, тамхи татахгүй байх	-	ХАБЭА Инженер, Химич	A	100%
Химийн бодис хадгалах агуулахыг стандартын дагуу ашиглах, тогтмол хянах, шаардлагатай тохиолдолд шинэчлэх, засварлах	-	Агуулахын менежер	A	100%
Ажиллагсдыг химийн бодистой ажиллах хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр бүрэн хангах, хэрэглэж хэвшүүлэх		ХАБЭА Инженер	A	100%
Химийн бодис асгарч алдагдах, ажиллагсад хордох, бэртэх гэмтэх, галын аюулын үед бодисыг хураан авах сав, хүрз, хоргүйжүүлэх саармагжуулах бодис урвалж, яаралтай тусламжийн эмийн сан, гал унтраах багаж хэрэгсэл, нөөц бололцоог бэлэн байлгах	Нормын дагуу хор саармагжуулах бүтээгдэхүүн олгосон.	ХАБЭА Инженер	A	100%
Химийн бодисын үлдэгдэл, сав баглаа боодлыг ил задгай хаяхгүй байх, зохих журмын дагуу устгах, зайлуулах, хяналт тавих	5.4 сая	Эрүүл ахуйч	A	100%
Химийн бодисуудын болон аюултай хог хаягдлын агуулахад химийн бодисуудын сав баглаа боодлыг хадгалахдаа эмх цэгцтэй, хаяг шошгожуулсан байх	-	Агуулахын ахлах ажилтан	A	100%
Болзошгүй эрсдэл тохиолдсон үед авах арга хэмжээ, эрсдэлийг бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрсдэлийн сан үүсгэх, байнгын бэлэн байдалд байлгах	-	ХАБЭА Инженер	A	100%
Нийт				100%

Хүснэгт 5. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ

### 3.5 Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Төсөл хэрэгжүүлэгч нь төслөөс хүрээлэн буй орчин, ажлын байрны дотор үзүүлж буй сөрөг нөлөөллийг тодорхойлох зорилгоор орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан хөрс, ус, агаараас жил бүр тогтоосон хугацаанд дээж авч, шинжлүүлэх, гарсан үр дүнг холбогдох байгууллагуудад тайлагнах үүрэгтэй.

Хяналт чиглэл	шинжилгээний	Дээжний тоо	Нийт төсөв мян, төг	Нийт гүйцэтгэл мян,төг
Агаар		1	600.0	583.0
Дуу чимээ-Дотоод орчны дуу шуугианы түвшин		4	280.0	280.0
Хөрс		3	450.0	227.0
Ус		12	-	АПУ ХК-ийн итгэмжлэгдсэн лабораториор сар бүрийн усны шинжилгээнд хамруулдаг
Бохир ус		12	-	
Нийт			<b>1330.0</b>	<b>1090.0</b>

Хүснэгт 6. 2024 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хийлгэсэн зардал

**А. Хөрсний шинжилгээ:** Байгаль орчны төлөв байдлын судалгааны ажлын хүрээнд үйлдвэрлэлийн хэсгийн талбайгаас хөрсний агрохими, хүнд металл, эрүүл ахуйн шинжилгээг хийхээр хөрсний дээжийг 2025/05/12-ны өдөр авч “Green Lab ” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.



Зураг 13. Хөрсний шинжилгээ авч байгаа байдал-Green Lab LLC

Сорьцны дугаар	Сорьц №1, 2, 3
Сорьц авсан гүн	0-10 см
Хөрсний өнгө	Цайвар хүрэн хөрс
Сорьц авсан цэг	Талбайн зүүн хэсэг

Хүснэгт 7.1 Хөрсний сорьц авсан тэмдэглэл

Дээж авсан цэг	Гүн, см	pH	Ялзмаг, %	Давс, %	ЦДЧ, dS/m	CaCO <sub>3</sub> , %	Солилцох суурь, мг-экв/100гр		Шим тэжээлийн элемент, мг/100г	
							Ca+2	Mg+2	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
Барилгажих талбай	10-20	8.04	1.57	0.03	0.073	0.00	17.5	3.8	2.2	21
Төслийн талбай	10-20	8.25	1.89	0.05	0.115	0.00	16.9	4.2	1.9	23

Хүснэгт 7.2 Хөрсний химийн шинж чанар (Дээж-1,2)

Хөрсний задлан шинжилгээний дүнгээр тус хөрс нь, ялзмагийн агууламж ихэвтэр, цахилгаан дамжуулах чадвар сул, хөрс ямар нэгэн давслаг бус, шингээгдсэн сууриудын нийлбэр 100 гр хөрсөнд 23.0мг/экв-аас кальцийн ион зонхилно. Ургамалд хялбар ашиглагдах шим тэжээлийн элементүүд болох хөдөлгөөнт фосфор их, кали ихэвтэр буюу бүтээгдэхүүнт чанар дунд зэрэг. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин дунд зэрэг байна.

Дээж авсан цэг	Механик ширхгүүд (%-иар), Ширхэгийн хэмжээ (мм-ээр)						
	Элс		Тоос			Шавар	Коллоид
	2.0-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Барилгажих талбай	26.8	48.8	7.4	3.5	7.4	6.1	17.0
Төслийн талбай	24.1	52.0	8.6	2.8	7.4	5.1	15.3

Хүснэгт 7.3. Хөрсний механик бүрэлдэхүүн (Дээж-1)

Компанийн талбайн хөрс нь механик бүрэлдэхүүнээр нарийн элс голлосон элсэн бүрэлдэхүүнтэй, нийт бүрэлдэхүүнд янз бүрийн ширхэгтэй элс /2-0.05мм/ давамгайлж 75.6%-ийг бүрдүүлсэн бол хөрсөн дэх шавар, тоосны агууламж 24.4% байна.

Цэгийн дугаар	Бохирдуулагч хүнд металл, мг/кг					
	Ni (Никель)	Cd (Кадми)	Pb (Хар тугалга)	Zn (Цайр)	Cr (Хром)	Cu (Зэс)
Барилгажих талбай	22,2	-	39.6	69.4	31.6	29.7
Төслийн талбай	29.0	-	44.3	68	42.8	32.5
<b>Зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019</b>						
Элсэрхэг хөрс	60	1.0	50	100	60	60
Шавранцар хөрс	100	1.5	70	150	100	80
Шаварлаг хөрс	150	3	100	300	150	100

Хүснэгт 7.4. Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн

Задлан шинжилгээний аргын стандартууд:

- Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд MNS3310:1991,
- Хөрсний агрохимийн бүрэлдэхүүн MNS6854:2020,
- Шинжилгээний стандарт MNS3297:2019
- Хүнд металлуудыг хаан дарсанд атом шингээлтийн спектрометрээр MNS ISO 11466:2007

Хөрсний хүнд металлын шинжилгээний дүнгээс үзэхэд элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй хөрсний хувьд Хар тугалга (Pb), Кадми (Cd), Хром (Cr), Никель (Ni), Цайр (Zn), Зэс (Cu)-ийн агууламж стандартын зөвшөөрөгдөх (MNS5850:2019) хэмжээнээс хэтрээгүй байна.

№	Дээжний дугаар	Нянгийн тоо MNS:ISO6341: 2012	Гэдэсний савханцрын титр (E.coli) MNS 5367:2004		Анаэробын (Cl.perfringens) MNS6341:2012	
		Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг

Хүснэгт 7.5. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дүн (Дээж-3)

Эх сурвалж: "Green Lab" ХХК-ийн Хөрсний итгэмжлэгдсэн лаборатори

Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дүнгээр бохирдлын зэрэг-1 цэвэр гэсэн үзүүлэлттэй байна (Шинжилгээний дүнг хавсаргав).

**Б. Агаарын шинжилгээ:** Байгаль орчны төлөв байдлын судалгааны ажлын хүрээнд барилгажих талбайд агаарын чанар, физик бохирдлыг тодорхойлох ажлыг Цаг уур, орчны шинжилгээний газар, Байгаль орчин хэмжилзүйн төв лаборатори хийж гүйцэтгэв.

Шинжилгээний арга зүй: Агаар дахь хийн хольцийн агууламжийг тодорхойлохдоо сонгомол дэвтээгч уусмалаар цэнэглэсэн шингээгч гуурсанд агаарыг соруулж аван азотын давхар исэл (NO<sub>2</sub>), хүхэрлэг хий (SO<sub>2</sub>)-г өнгөний эрчимшлийн буюу фотокалориметрийн аргаар MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021 стандартын дагуу тус тус тодорхойлсон бол агаар дахь тоосны агууламж, дуу чимээ, чичиргээ зэрэг үзүүлэлтүүдийг зөөврийн автомат багажаар ISO 9001:2000 стандартын дагуу тодорхойлсон.

Шинжилгээний үр дүн:

№	Сорьц авсан цэг	Солбицол	
1	Талбай	106 <sup>0</sup> 89895E	47 <sup>0</sup> 89490N

*Хүснэгт 7.6. Агаарын шинжилгээ хийсэн цэгийн газарзүйн солбицол*



*Зураг 14. Орчны агаарын шинжилгээ авч байгаа байдал-Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори*

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	SO мг/м <sup>3</sup>	NO мг/м <sup>3</sup>	Нийт тоосны агууламж, мг/м <sup>3</sup>	Дуу чимээ /ДБА/
1	Талбайгаас	10/10/25	21	27	315	60
2	Химийн бодис хадгалах өрөө		23	42	235	-
3	Үйлдвэр дотор орчин		34	37	154	82
<b>“Агаарын чанарын стандарт” MNS 4585:2025</b>			<b>450</b>	<b>200</b>	<b>500</b>	<b>85</b>

*Хүснэгт 7.7. Агаарын шинжилгээ*

Шинжилгээний үр дүнгээс харахад төслийн талбай орчмын агаар дахь SO<sub>2</sub>, NO<sub>2</sub>, нийт тоосны агууламж болон дуу чимээ нь “Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2025 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй үзүүлэлттэй байна.

**В. Усны шинжилгээ:** “АПУ” ХК, “Апу Дэйри” ХХК, УСУГ-ын итгэмжлэгдсэн лабораториудад 2025 оны 10, 11-р саруудад хийсэн усны шинжилгээнүүдийн дүнгээс харахад холбогдох стандартын ЗДХ-ээс хэтэрсэн үзүүлэлт гараагүй.

Шинжилгээний дугаар	Дээж авах стандарт	Дээжийн тодорхойлолт
2776-2779	MNS ISO 5667-5:2001	Технологийн ус, 200мл /4ш/

Хүлээн авсан огноо	Шинжилгээ дууссан огноо	Хэвлэсэн огноо
2025/11/04	2025/11/07	2025/11/10

№	Дээжний нэр	Шинжилгээний үзүүлэлт				
		Бактерын нийт тоо	<i>E.coli</i>	Salmonella,	<i>Pseudomonas</i> ,	Хөгц, Мөөгөнцөр
Байвал зохих үзүүлэлт MNS 0900:2018		<100.0	Илрэхгүй	Илрэхгүй	Илрэхгүй	-
Стандартын дугаар		MNS ISO 6222:1998	MNS ISO 19250:2017	MNS 6546:2015	MNS 5132:2002	
1	Нөөцийн танк-1	3	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй
2	Нөөцийн танк-2	1	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй
3	Нөөцийн танк-3	1	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй
4	Нөөцийн танк-4	1	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй

*Хүснэгт 7.8. Технологийн усны эрүүл ахуйн шинжилгээ*  
*Эх сурвалж: “АПУ Дэйри” ХХК, Итгэмжлэгдсэн лаборатори*

Дээж авах аргачлал	Дээжний нэр	Дээж авсан огноо	Шинжилгээ дууссан огноо
Дээж авах физик-химийн шинжилгээний графикийн дагуу	1. АПУ Дэйри-нөөц 2. АПУ Дэйри-мембран 3. АПУ Дэйри шугам	2025/10/09	2025/10/09

*Хүснэгт 7.9. Үйлдвэрийн усны шинжилгээ*

№	Үзүүлэлтүүд	Шинжлэх аргын стандарт	MNS 0900:2018	1	2	3
1	Усны орчин, рН	MNS ISO 10523-2:2001	6.5-8.5	6.94	7.09	6.88
2	Ерөнхий хатуулаг, мг- экв/л, ихгүй	MNS ISO 6059:2005	<7+0	2.60	2.35	1.85
3	Кальцийн ион, мг/л, ихгүй	MNS 1097:1970	<100.0	40.08	41.08	35.07
4	Магнийн ион, мг/л, ихгүй	MNS 1097:1970	<30.0	7.29	3.65	3.04
5	Хлорын ион, мг/л, ихгүй	MNS 4414:2005	<350.0	19.14	17.01	19.85

6	Гидрокарбонат ион, мг/л, ихгүй	MNS 4425:1997	-	91.5	61.0	61.0
7	Нитрат ион, мг/л, ихгүй	MNS ISO 7890:3-2001	<50.0	5.58	2.34	6.74
8	Нитрит ион, мг/л, ихгүй	MNS 4431:2005	<1.0	0	0	0
9	Аммонийн ион, мг/л, ихгүй	MNS 1097:1970	<1.5	0	0	0
10	Нийт төмрийн хэмжээ, мг/л, ихгүй	MNS 4430:2005	<0.3	0	0	0
11	Цахилгаан дамжуулах чанар, мс/см	MNS ISO 7888:1999	-	0.328	0.321	0.296

*Хүснэгт 7.10. Хаягдал усны шинжилгээ*

*Эх сурвалж: “АПУ” ХК, Итгэмжлэгдсэн лаборатори*

Ерөнхий шаардлага	MNS 6561:2025	Сорьц авсан огноо	2025\03\27
Сорьцын тодорхойлолт	Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус	Хүлээн авсан огноо	2025\03\27
Сорьц авсан аргачлал	MNS ISO 5667-10:2001	Шинжилсэн огноо	2025\03\27-03\29

д/д	Сорьцын код	Сорьц авсан газар	Сорьц авсан цэг	Хэмжээ
1	Б240607	ХУД, Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр	гадна худаг	0.5л

д/д	Шинжилгээний аргачлал	Шинжилгээний үзүүлэлт	Хэмжих нэгж	ЗДА	Б240607
Химийн шинжилгээний үр дүн					
1	MNS ISO 10523:2001	Усны орчин, рН		6-9	8.95
2	MNS ISO 11923:2001	Умбуур бодис	мг/л	100	44
3	MNS ISO 6060:2001	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч, ХХХ	мг/л	300	183.7

*Эх сурвалж: УСУГ, Усны төв лаборатори*

### 3.6 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын гүйцэтгэл

№	Ажлын чиглэл	2025 оны төсөв мян, төг	2025 оны гүйцэтгэл мян, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	15,700.0	
2	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	11000.0	
3	Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө	3000.0	
4	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Гүйцэтгэлээр	
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	880.0	
6	“Тэрбум мод” Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх	3000.0	3000.0
	Нийт		<b>78058.0</b>


*Хүснэгт 8. 2025 оны БОМТ-ний зардал*

## ДӨРӨВ. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Бид шингэн хүнсний салбарын тэргүүлэгч компанийн хувьд үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн сүлжээндээ өөрсдийн бэлтгэн нийлүүлэгч, харилцагчдаас байгаль орчны талаар илүү хариуцлагатай бодлого баримтлан хамтдаа харилцан туршлагаа солилцон тогтвортой хөгжихийг уриалан хамтран ажиллаж байна. Бид 2022 онд НҮБ-аас баталсан дэлхийн улс орнууд бүх нийтээр дэмжин хүн бүрт хөгжил цэцэглэлтийг хүртээмжтэй байлгах, ядуурлыг бууруулах, эх дэлхийгээ хамгаалахыг зорьж буй тогтвортой хөгжлийн 17 зорилтыг хэрэгжүүлэх хүчин чармайлтаа нэмэгдүүлэн ажиллаж байна. Бидний зорилго бол эх дэлхийдээ үзүүлэх аливаа сөрөг нөлөөллүүдийг хязгаарлаж, нийгэм, эдийн засагт оруулах эерэг хувь нэмрийг нэмэгдүүлэх юм. Үүний дотор байгаль орчин, тогтвортой хөгжлийн хувьд нөөцийн үр ашигтай менежментэд тулгуурлан байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлдвэрлэл эрхэлж тогтвортой нийгмийг бий болгоход хувь нэмрээ оруулах, байгаль орчны бодлого дор үйл ажиллагаагаа явууллаа. Тайлангийн дараах хэсгүүдээс үйл ажиллагааны гүйцэтгэлтэй танилцана уу.



### Монгол бахархал-Тогтвортой хөгжлийн стратеги-2030



Бид АПУ групп компанийн хэмжээнд “Монгол бахархал” Тогтвортой хөгжлийн стратеги-2030 төлөвлөгөөг баталсан. Тус төлөвлөгөөнд байгаль орчны бохирдолтой ул мөрийг арилгах зорилго тусгасан ба үүнд хаягдал усыг дахин боловсруулах, усны хэрэглээг багасгах, хог хаягдал, сав баглаа боодлын менежментийн стратеги хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, цэвэршүүлсэн бохир усыг дахин ашиглах үндэсний стандартын дагуу (MNS 6734:2018) цэвэрлэх байгууламжийг ажиллуулж байна. Мөн хүлэмжийн хийн ялгарлыг шат дараатай бууруулах арга хэмжээ авах гэх мэт ажлуудыг стратеги үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.

#### 4.1. Удирлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

АПУ Дэйри ХХК нь АПУ ХК-ийн охин компани бөгөөд Байгаль орчны дэд хэсэг нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны (ХАБЭАБО) албанд харъяалагддаг ба байгалийн нөөцийн менежмент, түүний зохистой хэрэглээ, хог хягдлын менежмент, хүрээлэн буй орчинд нөлөөлж болзошгүй эрсдэлийн менежмент, орчны хяналт шинжилгээ зэрэг чиглэлүүдэд үйл ажиллагаагаа явуулж Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг ханган ажиллуулах зорилттойгоор ажиллаж байна. 2024 оны БОМТ-ий хэрэгжилтийг шалгах ажлын хэсгээс гаргасан дүгнэлт, зөвлөмжийн дагуу дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээ.

##### Төлөвлөсөн арга хэмжээ 1

БОМТ-ний хэрэгжилтийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгжтэй байх

##### Ажлын гүйцэтгэл:

Байгаль орчны менежментийн тогтолцооны хэрэгжилтийг



сайжруулах ажлын хүрээнд үйлдвэрийн нэгж хэсгүүдэд байгаль орчны дэд багуудыг байгуулж, багийн гишүүдийг шинэчлэн үүрэг хариуцлагыг тодорхойлсон. Үүний үр дүнд компанийн ажилчдын идэвхи оролцоог нэмэгдүүлж, ажилчдын дундах байгаль орчны мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэн, зөв дадал зуршлыг суулгаж ажилтан бүрийн оролцоотойгоор байгууллагын байгаль орчны бодлогыг хамтдаа хэрэгжүүлж байна.

##### Төлөвлөсөн арга хэмжээ 2

Онцгой байдлын ерөнхий газартай хамтран ажиллах гэрээ байгуулж гэнэтийн осол эрсдэлийн талаар сургалт

##### Ажлын гүйцэтгэл:

HEINEKEN-ийн амь насаа хамгаалах 12 амлалтууд нь манай компанид ажилладаг бүх хүмүүст хамаатай аюулгүй ажиллагааны



дүрмүүд юм. Эдгээр нь эрсдэлийг бууруулах хөтөлбөрөөр дэмжигддэг бөгөөд ноцтой хүний амь нас алдах ослоос урьдчилан сэргийлэх түлхүүр юм. 2025 онд бид амь насаа хамгаалах 12 амлалтыг бүрэн мөрдөн ажиллаж байна.

АПУ ДЭЙРИ ХХК-н нь эрсдэл өндөртэй ажлын байранд ажилладаг ажилтнууд гэнэтийн ослын даатгалд 137 ажилтан, ажилтны хариуцлагын даатгалд 10 ажилтан “Хаан даатгал” компанитай хамтын ажиллагааны хүрээнд даатгуулсан байна

**Ажлын гүйцэтгэл:** Дэлхийн байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан АПУ групп компанийн хэмжээнд Тунгалаг туул-2025 аяныг зохион байгуулан аяны хүрээнд Баянзүрх хайрханы баруун хойд Туул голын сав газрыг мөн

**Төлөвлөсөн арга хэмжээ 3**

“Дэлхийн ойн өдөр” “Дэлхийн усны өдөр” “Эх дэлхийн цаг” Байгаль орчны тэмдэглэлт өдөрлөг 2025

Дунд голын сав газрыг цэвэрлэн ХУД-н хот тохижилтын хэсэгт хүлээлгэн өгөв.



Зураг 15. Тунгалаг туул-2025 аян

#### 4.2 Түүх, соёлын өвийг хамгаалах хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Бид монгол түмний бахархал болсон монгол сарлагаа ихэд дээдлэн уламжлал, шинэчлэлийг төгөлдөр тохируулж, эртний технологийн мөн чанарыг алдагдуулалгүй монгол угсаатны цагаан идээг орчин цагийн хүмүүн танд өргөн барьж байна. Сэтгэл оюуныг тань сэрээж, байгалийн шимийг дээжлэн урласан Mont-Yak эрхэм домог өгүүлж, үнэ цэн тээж хүрэх болтугай! Өвөг дээдсийн маань шүтээнийг алдаршуулан түгэх болтугай!



Сарлаг нь усны тунгалаг, өвсний дээжис эмийн ургамлаар идээшиж, цаг агаарын эрс тэрс сэрүүн нөхцөлд амьдардаг бөгөөд Монгол орны Алтай, Хангай, Хөвсгөлийн ай сав газар бэлчдэг.

Уламжлалт цагаан идээний соёлыг хадгалсан гэр үйлдвэрлэлийг хөгжүүлж, алслагдсан бүс нутгийн малчдын орлого, бүтээмжийг нэмэгдүүлэх экосистемийг хадгалах MONT-YAK брэндийг та бүхэнд зориулан бүтээв.

“АПУ Дэйри” Монгол сүүний үйлдвэр нь “Монгол Сарлаг” гэх үйлдвэрлэлийн төслөө Архангай аймгийн Чулуут суманд 2022 оноос эхлүүлсэн бөгөөд энэхүү төслийн хүрээнд сарлагийн сүүгээр хийсэн уламжлалт сүү цагаан идээг эрүүл ахуй, чанарын шаардлага хангасан гэр үйлдвэрлэлийн стандартыг нэвтрүүлж MONT-YAK брэндийн бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэж байна.

Сарлагийн шар тос, Амтат хайлмаг бүтээгдэхүүн нь органик хүнсний баталгаажилтын SFCS компаниас “Шилжилтийн үеийн органик хүнс” гэрчилгээг албан ёсоор гардан авсан. Органик хүнсний гэрчилгээ нь хүнс үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд органикийг баталгаажуулсны үндсэн дээр авдаг баталгаажилтын гэрчилгээ юм.



Эдгээр бүтээгдэхүүн нь төслийн хүрээнд гэр үйлдвэрлэлийн эхний шатны боловсруулалтад нэмүү өртөг шингээн Чулуут сумын ард иргэдээс түүхий эдээ хангаж Монгол Сарлагийн органик брэндийг бий болгож байгаа нь чухал ач холбогдолтой юм.

Органик хүнс хэмээн баталгаажуулж буй “АПУ ДЭЙРИ-Монгол сүүний үйлдвэрийн Сарлагийн эдгээр бүтээгдэхүүн нь шим тэжээл, уураг, тос, амин дэм, эрдэс бодисоор илүү баялаг сүүн бүтээгдэхүүнүүд болж чадсан юм.

#### МОНГОЛ ГАЗРЫН ЭМ, МОНГОЛ САРЛАГИЙН ШИМ

Монгол сарлаг нь Гималайн их уулсын мөнх цасыг ханзлан бууж Хантэнгэрийн ноён оргил, тэнгис далайг гатлан язгуурын нүүдэлчдийн өлгий нутгийг зорин ирсэн түүхтэй. Эрэмгий үзэсгэлэн гоо, энгүй их зориг, гайхам тэсвэр тэвчээрээр цуутай сарлаг нь хангай нутгийн тооно нь болсон өндөр уулсын урсгал тунгалаг усаар ундаалж, шимт хөрсөнд соёолсон ургамлыг хүртэхийн учир шимийн дээд удвдсыг сүүндээ шингээж үл орлох амин дэм, эрдсээр баялаг байдгаараа онцгой үнэ цэнтэй.



#### 4.3 Төлөвлөгөөний хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоо, тэр дундаа төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заасан хүрээнд тэдэнд аль болох ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит

мэдээллийг өгч, зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал бодлыг судлан тусгах нь энэ шатны ажлын гол зорилго юм.

№	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1.	Хорооны иргэдийн төлөөлөл	Тайлагнах, хэлэлцүүлэх	Төслийн үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдэж буй ажил	Жил бүрийн 10 сард	1,000,000	ХАБЭА инженер	Компанийн байранд
2.	Нийслэлийн байгаль орчны газар	Тайлагнах	Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин ажлын байранд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах талаар хийгдсэн ажил, БОМТ-ний тайлан	Жил бүрийн 11 сард	Дотоод үйл ажиллагааны зардал	ХАБЭА инженер	Нийслэлийн байгаль орчны газар
3.	БОУАӨЯам Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газар	БОМТ-ний тайлан, төлөвлөгөөг батлуулах	Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин ажлын байранд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ авах, хяналт шинжилгээний дагуу хийсэн ажлыг	Жил бүрийн 12 сар	Дотоод үйл ажиллагааны зардал	ХАБЭА инженер	БОАЖЯ Eic.mn БО-ны мэдээллийн санд тухайн жилийн биелэлтийн тайлан болон дараа жилийн төлөвлөгөөг оруулах
<b>Тодорхойлсон нийт төсөө:</b>					<b>1,000,000</b>		

*Хүснэгт 9. Төлөвлөгөөний хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах зардал*

  
**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
19 ДҮГЭЭР ХОРООНЫ ЗАСАГ ДАРГА**  
 Туул гол гудамж, 19 дүгээр хороо  
 Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17042  
 Утас: (976) 7729 6519  
 Цахим шуудан: hnd\_19@nsood.mn  
 Цахим хуудас: www.khanuul.mn  
 2025.08.19 № 114  
 таяг \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН  
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМАНД**

Тус хороо нь 2019 оны Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 35 дугаар тогтоолоор Хан-Уул дүүргийн 15 дугаар хороо нь бүтэц зохион байгуулалтын хувьд өөрчлөлт орж 19 дүгээр хороо шинээр үүсгэн байгуулагдсан бөгөөд одоогоор Иргэдийн нийтийн хурал байгуулагдаагүй болно.

Иймд "АПУ Дэйри" ХХК-ийн сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр "Эко дэйри" төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг иргэдийн хурлаар хэлэлцэн дэмжив.



Ш.НОРОВЦЭРЭН

АПУ дэйри ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн З.Рэнцэнханд: Хими болон микробиологийн лаборатортай хими микробиологын шинжилгээ хийдэг. Нангын тэжээлт орчинг устгалын тусгай Түмэн элшиг ХХК-тай гэрээний дагуу устуулдаг.

Иргэн С.Гантоого: Хэдэн төрлийн ашигтай бактертай бүтээгдэхүүн гаргадаг вэ? Ашигтай бактераа нэмж болох уу?

АПУ дэйри ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн З.Нарантуяа: 10 тарбум ашигтай бактертай тараг, исуртг үйлдвэрлэдэг. Үйлдвэртэй уламжлан хэлбэр.

Иргэн С.Гантоого: Хиндэн л ус хэрэглэдэг вэ? Бохир усаа яаж зохицуулдаг вэ?

АПУ дэйри ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн З. Рэнцэнханд: Хоногт 700л, хаягдал ус 700л гэж тооцдог. Усаа шугамаар татах төслийн барилга баригдаж байгаа 2028 онд ашиглагдана.

Иргэн С.Гантоого: Аюултай хог хаягдлаа хэрхэн шийддэг вэ?

АПУ дэйри ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн З. Рэнцэнханд: Аюултай хог хаягдлаа тусгай саванд хийж гэрээт Түмэн элшиг ХХК-тай гэрээний дагуу устуулдаг.

Нийгмийн ажилтан Ц.Хишигсүрэн: Машин цэвэрлэгээ яаж хийдэг вэ?

АПУ дэйри ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн З.Рэнцэнханд: Цэвэрлэгээг үйлдвэрээс гарах сааварал усаар угааж цэвэрлэдэг.

Хурлын шийдвэр: Тус хорооны нутаг дэвсгэрт байрлах АПУ дэйри ХХК-ны сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэр "Эко дэйри" төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг хэлэлцээд иргэдийн хурлын шийдвэрийн 80% саналаар дэмжих шийдвэрлэл.

Хурал 2025.08.19 ны өдрийн 16.10-д дуусав.

ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН

ЗАСАГ ДАРГА

Ш.НОРОВЦЭРЭН

ТЭМДЭГЛЭЛТЭЙ НЭГЭЭ

НИЙГМИЙН АЖИЛТАН

Ц.ХИШИГСҮРЭН

**СУРГАЛТАД ХАМРАГСАН АЖИЛТНУУДЫН БҮРТГЭЛ**

Сургалтын нэр: **БОМТ үйл ажиллагааны хурал**

Огноо: **2025.08.19**

Засвар байгууламдаг газар: **ХУД-ийн 19-р хороо**

Сургалч багш:

Үргэлжлэх хугацаа:

№	Оролгогчдын овог нэр	Албан тушаал	Гарын үсэг	Тайлбар
1	Т.Элсэл	иргэн ажилтан	[Signature]	244.8048
2	С.Төгс	9А-2 Төмөрч	[Signature]	899.87851
3	У.Төгс	иргэн ажилтан	[Signature]	8799.000
4	У.Төгс	иргэн ажилтан	[Signature]	812.3559
5	В.Ариун	Төрийн ажилтан	[Signature]	880.000
6	М.Оюун	МОН-ийн иргэн	[Signature]	80.00.9259
7	С.Төгс	иргэн ажилтан	[Signature]	899.849
8	С.Төгс	иргэн ажилтан	[Signature]	858.0405
9	С.Төгс	иргэн ажилтан	[Signature]	890.0785
10	С.Төгс	иргэн ажилтан	[Signature]	844.839
11	В.Ариун	иргэн ажилтан	[Signature]	888.000
12	С.Төгс	иргэн ажилтан	[Signature]	9120.00.10
13	С.Төгс	иргэн ажилтан	[Signature]	88.00.8922
14	С.Төгс	иргэн ажилтан	[Signature]	888.000
15	С.Төгс	иргэн ажилтан	[Signature]	888.000

БҮРТГЭЛ ГАРГАСАН АЖИЛТАН **3 Aug 1**

ОГНОО **2025.08.19**

**Зураг 16. ХУД-н 19-р хорооны засаг даргын албан бичиг болон хурлын протокол, тайлан**



**2025.08.19 өдөр ХУД-н 19-р хорооны иргэд нийтийн хуралд тус хорооны 14 иргэнд БОМТ үйл ажиллагааны тайлангаа тавив.**

#### **4.4 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

Төслийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд нөлөөлж буй болон болзошгүй аливаа сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлж байна.

#### ***Жилийн туршид тогтмол хийн гүйцэтгэсэн ажлууд:***

Үйлдвэрийн гадна орчныг эмх цэгц, цэвэрлэгээ, үйлчилгээг улирал болгон тогтмол зохион байгуулан бүх нийтийн их цэвэрлэгээ хийн компанийн гадна болон дотор талбайд цэвэрлэгээ үйлчилгээг зохион байгуулж байна.



*Зураг 17. Компанийн ойр орчмын талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, ногоон байгууламжын арчилгаа*

**А. Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

Техник тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг тогтмол хянан ханган ажиллаж хүрээнд түүхий эд болон эцсийн бүтээгдэхүүний тээвэрлэлтэд ашиглах машиныг жил бүрийн тогтмол техникийн үзлэг оношилгоонд оруулан, агаар бохирдуулсны төлбөрийг төлсөн. 25 машин улсын үзлэг оношлогоонд орсон, тээвэрийн хэрэгслийн даатгал болон агаар бохирдуулсны төлбөр төлсөн.

**Б. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

**Төлөвлөгөөний гүйцэтгэл:** АПУ ХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид сар бүр үйлдвэрийн хаягдал бохир усны шинжилгээг хийн гүйцэтгэж хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэрлэсэн бохир усны техникийн шаардлага MNS 4943:2015 стандартын үзүүлэлтүүдийг тогтмол хянаж байна. Мөн улирал бүр Ус сувгийн удирдах газрын лабораторид бохир усны дээжийг шинжлүүлэн баталгаажуулан тогтмол хяналтандаа байлгаж байна.

Усны нөөцийг хэмнэх, дахин ашигласан усны хэмжээ, хэрэглээг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд үйлдвэрийн цех бүрийн усны хэрэглээг нарийвчлан тооцон анализ хийж, тоног төхөөрөмж, шугам хоолойн алдагдлыг олж тодорхойлон инженерийн болон техникийн аргачлалаар шийдвэрлэн сайжруулах, шинэчлэх арга хэмжээнүүдийг авч нэгж бүтээгдэхүүнд зарцуулагдах усны нормыг хамгийн боломжит бага хэмжээнд хүргэж өмнөх онтой харьцуулахад 1.9Hl -р усны хэрэглээгээ буурууллаа.




График 1. Усны зарцуулалт болон үйлдвэрлэлийн тоо хэмжээтэй харьцуулсан

## **В. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

### **Жилийн туршид тогтмол хийн гүйцэтгэсэн ажлууд:**

Тусгай зөвшөөрөл бүхий хог хаягдлын үйлчилгээ үзүүлэх, дахин боловсруулах устгах үйл ажиллагаатай байгууллагуудтай гэрээ хэлэлцээрийн дагуу ажиллаж үүссэн болон цугларсан хатуу ба аюултай хог хаягдлыг тухай бүр ачуулан дахин боловсруулах болон устган зайлуулах арга хэмжээ рүү шилжүүлж байна. Хог хаягдлын төвлөрсөн цэгт ангилан ялгалтын дагуу хуримтлуулж холбогдох компаниуд руу нийлүүлдэг ба тогтмол цэвэрлэгээ үйлчилгээ хийгддэг тул хөрсөн давхаргад нөлөөлөх шууд сөрөг нөлөөгүй. Үйлдвэрийн нийт ногоон байгууламж бүхий талбайг тогтмол тордон арчлан, усладаг. Машин техникийг тогтоосон тээврийн хэрэгслийн зам талбайгаар зохицуулдаг.

## **Г. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

### **1. “Тэрбум мод” төсөл**

Нийслэлийн Байгаль орчны газартай хамтран нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Нийслэлийн засаг даргын 2021 оны А/908 дугаар захирамжийн дагуу “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангуулж ажиллахаар нийслэлийн нутаг дэвсгэрт нэгдсэн зохион байгуулалтаар шинэс мод тарих ажилд АПУ Дэйри ХХК компани нь 200 ширхэг нарс болон шинэс мод тарихаар НУРИ ХХК хамтран ажиллахаар гэрээг байгуулж ажиллалаа. */Хавсралт дэлгэрэнгүй мэдээлэл тайлан, хамтын ажиллагааны гэрээ, албан бичгийг харна уу/*

#### **Төлөвлөгөөний гүйцэтгэл:**

1. Үйлдвэрийн гадна орчинд жил бүр мод суулгацыг арчлан, услаж, зүлэгжүүлдэг.
2. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд АПУ Дэйри ХХК нь НУРИ ХХК-тай хамтран Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 21-р хороо, “Инчон” мөрөөдлийн цэцэрлэгт хүрээлэнд 100 ш нарс мод, 100 ш шинэс мод тарив.



*Зураг 18. Тэрбум мод үндэсний хөдөлгөөн*

**Д. Цахилгаан эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

2025 онд цахилгаан эрчим хүчний хэрэглээг бууруулах зорилтын хүрээнд эрчим хүчний баг болон эрчим хүчний хэмнэлтийн хөтөлбөрийн хүрээнд цахилгаан, уур, дулааны алдагдлыг тодорхойлон, энергийн алдагдлыг арилгаж хэрэглээний хэмнэлтийг хийж байна. Уур, дулаан, цахилгааны зарцуулалт үйлдвэрийн хэсэг бүрээр тодорхойлон хянаж, их хэрэглээтэй нэгж хэсэг болон тоног төхөөрөмжийн хэрэглээг бууруулах, сайжруулах арга хэмжээнүүдийг авч байна.



Зураг 19. Ажлын байрны гэрэлтүүлгийг лэд гэрлээр солив



График 2. Цахилгааны зарцуулалт болон үйлдвэрлэлийн тоо хэмжээтэй харьцуулсан байдал



График 3. Уурын зарцуулалт болон үйлдвэрлэлийн тоо хэмжээтэй харьцуулсан байдал



Зураг 20. Усны тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээ

#### **4.5 Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт**

Химийн бодисын хадгалалтад Монгол Улсын хууль, дүрэм журмууд болон компанийн дотоод журам болох химийн бодисын хяналтын тухай журмын дагуу хяналт тавин ажиллаж байна. Компанийн хэмжээнд нийт 61 нэр төрлийн химийн бодисыг “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, худалдан авах, тээвэрлэх, ашиглах” тусгай зөвшөөрлийн хүрээнд төв лаборатори болон үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угаалга цэвэрлэгээнд ашиглаж байна. Үйлдвэрийн технологи болон тоног төхөөрөмжийн угаалга цэвэрлэгээнд ашиглах бодисуудыг “Sopura” олон улсын компанийн бодисыг хэрэглэдэг ба лабораторийн хэрэгцээний химийн бодисуудыг дотоодын компаниудаас худалдан авдаг. Бодисуудын сав, баглаа боодол бүрэн бүтэн эсэхийг шалган тээвэрлэх бөгөөд бодисууд нь хоруу чанар багатай, тогтвортой шинж чанартай. Хадгалалтын хувьд химийн бодисуудыг “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага. “MNS 6458:2014”-ийн шаардлага хангасан агуулахад хадгалах журмын дагуу ангилан, нэр хаяг, шошго, анхааруулах үг, тэмдэг тэмдэглэгээ, хор аюулын мэдээллийг байршуулан хадгалах тул санамсаргүй осол, эрсдлээс бусад тохиолдолд сөрөг нөлөө бага. Үйлдвэр үйл ажиллагааны хүрээнд ашиглаж буй бүх химийн бодисыг ХАЛМ-тай байлгаж бүртгэлжүүлэн ажиллаж байна. Бодисууд нь 25-200 кг болон 20-200 л-ийн хэмжээ шуудай, хуванцар савлагаатай.

**Төслийн хүрээнд 61 гаруй төрлийн химийн бодис, урвалж, бүтээгдэхүүнийг зөвшөөрлийн дагуу ашигладаг.**

##### **Тээвэрлэлтийн үед үүсч болзошгүй эрсдэл:**

- Тээвэрлэлтийн явцад химийн бодисыг тээвэрлэх журам, аюулгүй ажиллагааг баримтлаагүйн улмаас бодис асгарч алдагдах, хөрс, ус бохирдуулах, жолооч, ачигч, ажиллагсдыг хордуулах, галын аюул, осол зэрэг эрсдэл үүсч болзошгүй юм.
- Химийн бодисуудыг ачиж буулгах үед бодис асгарч, алдагдаж байгаль орчныг бохирдуулах, жолооч ажиллагсад хордох эрсдэл үүсч болзошгүй.
- Тээвэрлэлтийн явцад бодисын сав, баглаа боодлын бүрэн бүтэн биш байдлаас үүдэн химийн бодис асгарч алдагдсанаар байгаль орчин бохирдох, галын аюул, осол үүсч болзошгүй.
- Тээврийн хэрэгслийн эвдрэл, гэмтэл мөн жолооч, ачигчдын болгоомжгүй үйлдлийн улмаас бодис асгарах, галын аюул, осол үүсч болзошгүй.







##### **Хадгалалтын үед үүсч болзошгүй эрсдэл:**

- Хадгалалтын явцад химийн бодисыг хадгалах журам, хор аюулын мэдээлэлд заасан зааврыг мөрдөөгүйн улмаас бодис асгарах, бодисын шинж чанар муудах, байгаль орчин, ажлын байр бохирдож болзошгүй.
- Химийн бодисын сав, баглаа боодлыг задлан ил задгай, хяналтгүй хадгалсны улмаас бодисын тоос агаарт тархах, бодис асгарах, мөн бодисын шинж чанар өөрчлөгдөх, байгаль орчинд бохирдол үүсгэх зэрэг эрсдэл үүсч болзошгүй.
- Химийн бодис хадгалж буй агуулахын цонх, битүүмжлэл бүрэн бүтэн байдал алдагдсаны улмаас бодисын хадгалалтын горим алдагдах, осол аюул үүсч болзошгүй.
- Ажиллагсад бодистой ажиллах үед аюулгүй ажиллагаа, хувцас хэрэгсэлгүйн улмаас арьс салст, нүд амьсгалын замаар хүрэлцэх, хордох зэргээр эрсдэлд өртөж болзошгүй.
- Бодисын хяналтгүй асгаралт, алдагдлын улмаас агаарт хорт хий ялгарах, хүн ам, эд хөрөнгө, тоног төхөөрөмж эвдэрч сүйдэх зэргээр осол аюул үүсч болзошгүй.

**Ашиглах явцад үүсч болзошгүй эрсдэл:**

- Химийн бодисуудыг задлах, уусмал бэлтгэх, савлах зэргээр химийн бодистой ажиллах явцад бодис асгарах, уурших зэргээр ажиллагсдыг хордуулж болзошгүй.
- Санамсаргүй ослын улмаас химийн бодис асгарах, алдагдах тухайн орчныг бохирдуулах, ил гал, дөлний улмаас галын аюул үүсч болзошгүй.
- Ажиллагсад бодистой ажиллах үед аюулгүй ажиллагаа, хувцас хэрэгсэлгүйн улмаас арьс салст, нүд, амьсгалын замаар хүрэлцэх, хордох зэргээр эрсдэлд өртөж болзошгүй.
